

“БАЯНТЭЭГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 сарын 13 өдөр

Арвайхээр сум

“Баянтээг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 2021 оны 04 дүгээр сарын 13-ний өдрийн 11 цаг 15 минутад zoom аппекайшнаар буюу онлайнаар хурал эхлэв.

Тооллогын комиссын гишүүн Б.Онон тооллогын дүнг танилцуулав.

Компанийн тухай хуулийн 67.3.1, 69.1, 69.2 болон “Баянтээг” ХК-ийн дүрмийн 6.4 “Баянтээг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баянтээг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 252608 ширхэг энгийн хувьцаа байдаг үүнээс 2356588 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий 252,608 ширхэг энгийн хувьцааны 93,6%-ийн ирцтэйгээр тус хурал болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1, 69.2 дах заалт, компанийн дүрмийн 6.4 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 93.6%-ийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай. Тооллогын комиссын дарга Л.Ган-Отгон тооллогын комиссын гишүүн Б.Онон

Хурал даргалагчид хурлын ирц хангалттай байгааг танилцуулж, тооллогын комиссын тогтоолын төслийг батлуулж, хурал эхэлсэнийг албан ёсоор зарлаж хурлын дэгийг танилцуулан батлуулан, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Хурлаар хэлэлцсэн асуудлуудын жагсаалт:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг батлах
2. Компанийн 2020 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг батлах
3. Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах
4. Компанийн 2021 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэж батлах
5. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2021 оны цалин урамшуулал болон зардлын төсөв батлах
6. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
7. Аудитын байгууллагын тайлан дүгнэлт
8. Бусад

Д.Нэмэхбаяр: 1-р асуудал Компанийн 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан Баянтээг ХК-ийн гүйцэтгэх захирал Н.Данзан танилцуулав.

А.Ишдорж: Авлага яагаад 336,4 сая төгрөгөөр өссөн бэ?

Н.Данзан: Энэ жил Засгийн газар халаалт хариуцна гэсэнтэй холбогдуулаад дулаан үйлдвэрлэгч нарт мөнгө нь орж ирэхгүй байна гэсэн шалтгаан хэлсэн. махны үйлдвэрийн 220 сая төгрөг, хайгуулын нөхөн төлбөрийн өр 771 сая төгрөг байгаа. Бид өр төлбөр барагдуулах тал дээр 2021 оны 05 сарын 01 өдрийн дотор төлбөрөө барагдуул гэсэн албан бичиг өгсөн. Төлж чадахгүй бол дараагийн шатны байгууллагад хандана гэж бодож байгаа.

А.Ишдорж: Танайх аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулахдаа хугацаандаа төлбөрөө төлөөгүй бол хүү эсвэл алданг тооцож авч байгаа юу? Энэ дээр ямар арга хэмжээ авч байна.

Н.Данзан: Гэрээн дээр сар болгон 0.5%-иар алданг тооцно гээд тусгасан байгаа. 2019 оны санхүүгийн тайланд төрийн аудитын шалгалтаар хугацаа хэтэрсэн гэрээний алданг 300 сая төгрөг авахаар байна гэсэн. Гэхдээ шүүхэд шилжүүлээд алданг тооцож авсан компани байхгүй өнөөдрийн байдлаар бид хариуцагч компаниа оны эцсийн өр авлага ямар ч байсан барагдуул гэсэн шаардлагыг байнга тавьж байгаа. Нэмж нүүрс өгөхгүй хаасан байдалтай л байна.

А.Ишдорж: Авлага өглөгийн тооцоон дээр хэрэглэгч гэж хэнийг хэлж байна.

Н.Данзан: Гэрээтэй компаниудын өр

Ю.Батсайхан: Нүүрс олборлолт нийт 221.000 тн, хөрс хуулалт 822.000 кв хуулна гэж байна баруун урд талын 2 отволоос хөрсөө тавьж байгаа юу?

Л.Энх-Отгон: Алсдаа хайгуул хийвэл гэж бодоод карьерынхаа хойд талд овоолгуудаа үүсгэж байгаа. Тэнд ойрын хэдэн жил овоолго байгуулаагүй.

Ю.Батсайхан: Гүнрүүгээ нүүрс олборлосон байна энэ чанар нь ямар байна.

Л.Энх-Отгон: Нүүрсний чанар доошлох тусмаа гайгүй байгаа.

Ю.Батсайхан: 8 сард өгсөн шинжилгээний бичиг байна тэр нь дээр хүхрийн агууламж хэд гэж байна. Хамгийн гол юм бол хүхэр гүнрүүгээ яаж өөрчлөгдөж байна вэ? Хүхэр бол хортой хольц тийм учраас маш чухал.

Л.Энх-Отгон: Хүхрийн шинжилгээний бичиг байгаа хүхэр 0,8%-тай байдаг.

Ю.Батсайхан: Цахилгаан станц барина гээд ТЭЗҮ хийж байгаа үүнийг үндсэн баримт нь барих уу үгүй юу гэдгийг шийдэх үзүүлэлт бол хүхрийн агуулга. Хүхрийн агуулга ихтэй байвал цахилгаан станцын тоног төхөөрөмжийг элэгдүүлээд эвдээд дуусна. Байгаль орчинд ч хортой. Үүнийг Энх-Отгон хариуцаад нүүрсний чанарын судалгааг маш сайн хийлгэх хэрэгтэй одоо байгаа нүүрсний улан дээр шүүлт тавиад тэрийгээ метр метрээр аваад шинжилгээнд өг. Гэхдээ Эс Жи Эс гээд олон улсын магадлан итгэмжлэгдсэн лаборатор бий тэнд бас давхар 2 газар өгөөрэй.

Л.Энх-Отгон: Стандартаа шинэчилмээр байна 1984 онд батлагдсан стандарт байгаа. Тэр үед хүрэн нүүрсээр тогтоогдсон одоо бол манайх чулуун нүүрс рүү шилжүүлж стандартаа шинэчилмээр байна.

Ю.Батсайхан: Стандартын газар хүсэлтээ өгөөд нүүрсний чанарын шинжилгээгээ өгчихөд болно.

Ю.Батсайхан: Ер нь цаашид зүмшний аргаар усаа шүүрүүлэхэд технологийн хувьд асуудал байхгүй гэж ойлголоо.

Л.Энх-Отгон: Ойрын хэдэн жилдээ асуудал байхгүй.

Ю.Батсайхан: 2020 онд өрөмдлөг тэсэлгээ хийсэн үү? Хийгээгүй бол хөрс хир хатуу байв экскаваторын шүд, соёо болон техникүүдэд хир гэмтэл гарсан.

Л.Энх-Отгон: 2020 оны 04 сарын 10нд тэсэлгээний зөвшөөрлийн хугацаа дууссан тэгээд ковид гээд хөл хориотой байгаад сунгаж чадаагүй. Энэ жил сунгах гээд хөөцөлдөж байгаа.

Ю.Басайхан: Тэсэлгээгүй хөрсөө хуулж чадаад байгаа юм бол тэсэлгээний хэрэг байна уу?

Л.Энх-Отгон: 1,2-р үедээ бол гайгүй тэрнээс доошлох тусам хатуураад байгаа.

Ю.Батсайхан: Энэ өндөр зардалтай шүү үүнийгээ зөв тооцож тусгаарай тэсэлгээний ажил бол том ажил.

Ю.Батсайхан: Усны хатуулаг өндөр байна гэж байна энэ тал дээр ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ?

Н.Данзан: Ахуйн хэрэглээнд болон барилга байгууламжийн дулааны шугам амархан цоорч гэмтдэг асуудлууд байгаа. Нийт ард иргэдийн ахуйн хэрэглээнд хэрэглэдэг худганд ус зөөлрүүлэгч төхөөрөмж тавьсан байна лээ тэр төхөөрөмж тавьсан үеийнх шигээ байж чадахгүй байгаа шинээр төхөөрөмж авч тавих гэхлээр худагны барилга багадаа болохгүй байна. Худагныхаа барилгыг томсгож байж шинээр төхөөрөмж авч тавих шаардлагатай байгаа.

Ю.Батсайхан: Шахмал түлшний үйлдвэрийн цавууны 300 сая төгрөг бол төлөвлөөгүй орж ирсэн ажил энэ ажлыг хийхэд ТУЗ-ийн гишүүн миний бие оролцоогүй үүнтэй холбоотой тайлан гэж байна уу? Үүнийг дэлгэрэнгүй тайлбарлаж өгнө үү?

Н.Данзан: Би ажил аваад удаагүй байсан аймгийн удирдлагуудын гол ярьж байсан зүйл бол шахмал түлшний үйлдвэрийг ажиллуулж, ашиглалтанд оруулж, шахмал түлш үйлдвэрлэх асуудал байсан. Баялаг эрдэнэ цом компаний хүн бол цавууны машин аваад өөрсдөө цавуугаа хийх юм бол цаашдаа зүгээр юм байна гээд цавууны машин үзлээ авья гээд маш түргэн хугацаанд шийдэж шийдвэр нь гарсан. Энэ цавууны машин маш өндөр 300-400 градус халааж будааг цардуул болгож шавартайгаа хольж барьцалдуулагч болгож байгаа. Таван толгой компани Хятад улсаас цавуугаа хэдэн тэрбумаар зөөж авдаг байсныг Засгийн газраас болиулаад дотоодын үйлдвэрээ дэмжиж цавууг дотооддоо үйлдвэрлэхээр тэндэр зарласан гэсэн. Энд тэндээс хүмүүс ирээд танай үйлдвэрт давуу тал их байна бүх юм аа өөрсдөө хийж байгаа нь маш чухал коксоо, цавуу, барьцалдуулагчаа өөрсдөө гаргаад шахмал түлш үйлдвэрлэж байгаа нь зөв зүйтэй юм аа энэ цавуу үйлдвэрлэдэг машин үр өгөөжөө өгөх байхаа. Боломжийн зөв шийдэл гэж миний хувьд бодож байна.

Ю.Батсайхан: Энэ үйлдвэр анхнаасаа төлөвлөгөөгүй баригдсан үйлдвэр үүнийг Нэмэхбаяр дарга мэдэж байгаа ТЭЗҮ гэж юм байхгүй зүгээр тэр Ганзориг гэж хүний үгээр энд ийм юм сайн тэнд тийм юм сайн гэхээр аваад тавиад байдаг түүний нэг жишээ нь цавууны үйлдвэр. Энэ цавууны хэсэг ажилд ороод хэр удаж байгаа юм. Хэдэн тн цавуу үйлдвэрлэсэн бэ?

Н.Данзан: 100 тн шахмал түлш үйлдвэрлэсэн түүний цавууг үйлдвэрлэсэн. Ер бол бид өмнөх тооцооноос арай өөр тооцоо гаргаж ирсэн Арвайхээрийн хэмжээнд 15.000 тн шахмал түлш борлуулна гэсэн тооцоо гаргаж ирсэн тэрнийхээ цавууг бол үйлдвэрлэнэ гэсэн тооцоотой байгаа.

Ю.Батсайхан: Одоо нэгэнт авсан юм чинь ажиллуулмаар байна. Хамгийн гол асуудал барьцалдуулагчийн талаар хүний биед хортой, хоргүй гэж дүгнэлт гарсан уу?

Н.Данзан: Цавууны талаар дүгнэлт гарсан. Ашиглаж байгаа материал нь будаа учраас ямар нэгэн хортой зүйл байхгүй.

Ю.Батсайхан: Энэ 100 тн шахмал түлш үйлдвэрлэсэн үүнийгээ түлж үзсэн үү? зарах ч юм уу?

Н.Данзан: 100 тн шахмал түлшээ Арвайхээрлүү ачуулсан байгаа. Туршилтын журмаар зууханд түлж үзэхээр явуулсан.

А.Ишдорж: Эхний ээлжинд уурын зууханд түлж байна. Илчлэг, утаа, үнслэг чанар нь ямар байна гэдгийг судлуулахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа. Мөн өрх айлуудыг сонгоод хэд хэдэн айлд түлүүлж үзье янз бүрийн зуухтай айлд туршиж үзэж байгаа. Дулаан барих чадвар зэргийг үзэхээр үүрэг даалгавар өгөөд ажиллуулж байна. Одооноос бэлтэглээ хангаж байгаад 9 сараас халаалт эхлэхээр шууд нэвтрүүлэхгүй бол бидэнд туршилтын хугацаа байхгүй. Янз бүрийн хүний биед хортой нөхцөл байдал үүсвэл хэл ам хэцүү болно гээд бэлтгэлийг хийлгүүлээд явж байна ер нь ойр ойрхон нилээн анхаарч ажиллана. Мөн Эрчим хүчний яамны зөвлөлөөс ажлын хэсэг ирж үзсэн үүнд цаашид юу анхаарах ёстой байна гэсэн дүгнэлт гаргаж явуулна гэсэн тэр дүгнэлт нь хараахан ирээгүй байна. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооноос Алтанзул дарга ирж танилцсан агаарын бохирдлын сангаас нэмэлт санхүүжилтийн асуудлыг шийдсэн байгаа үндсэндээ 2 ажлын хэсгийн хороо ирж ажилласан байгаа.

Ю.Батсайхан: 2020 орлого 2 тэрбумаар тасарсан байна.

Ю.Ариунтунгалаг: Шахмал түлш борлуулна гэж төлөвлөсөн боловч борлуулалт огт хийгдээгүй.

Ю.Батсайхан: Энэ дээр компани үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилтоо биелүүлсэн гэж үзэх үү юу гэж дүгнэх вэ?

Н.Данзан: 2020 оны зорилт болон үндсэн ажил болох хөрс хуулалт, нүүрс борлуулалтын ажил төлөвлөгөөнөөс хоёулаа давсан байгаа. Тийм учраас 2020 оны Баянтээг ХК-ийн үндсэн үйл ажиллагаа болон төлөвлөгөөгөө хангалттай ажилласан гэж дүгнэж байгаа. Шахмал түлшний үйлдвэрийн орлого, зардал манай төлөвлөгөөнд нөлөөлөөд байгаа юм аа

Ю.Батсайхан: Шахмал түлшний үйлдвэрийг тусдана гаргах шийдвэр гарсан юм уу?

А.Ишдорж: Аймгийн ИТХ-аас шахмал түлшний үйлдвэрийг тусдана гаргая гээд орон нутгийн өмчит компани байгуулаад ТУЗ-ийг нь байгуулсан одоо гүйцэтгэх захирлыг нь

томилох гэж байна. Өмнө Баянтээгийн уурхайд инженерээр ажиллаж байсан инженер мэргэжилтэй залууг томилогдох гэж байгаа. Агаарын бохирдлын сангаас дэмжлэг хүрээд ирвэл бие даалгачих бодолтой байна.

Миеэгомбо: Шахмал түлшний үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаанд бид нар бодитой үнэлэлт дүгнэлт өгөх ёстой. Эхнээсээ ТЭЗҮ байхгүй аж ахуйн аргаар явсан ТЭЗҮ байхгүй учраас хөрөнгө оруулалтын хэмжээ анхнаасаа тодорхойгүй байсан. Бид нарын оролцоотой оролцоогүй олон янзын санхүүжилтийг уурхайгаас авсан гэж би ойлгож байгаа. Шахмал түлшний үйлдвэрийг бие даалгахын өмнө өнгөрсөн хугацаанд нь санхүүгийн үйл ажиллагаанд бид нар аудит хийлгэх ёстой аудит хийлгэх талаар хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гарсан тэрийг бол нүглийн нүдийг гурилаар хуурна гэдэг шиг оромдоод өнгөрөөсөн 4 том аудитын компани нэгээр хийлгэе гэж ярьсан боловч хэний ч мэдэхгүй компаниар аудит хийлгэсэн шахмал түлшний үйлдвэр баригдаж эхэлсэнээс хойших 2016-2020 он хүртэл хугацаанд олон улсын шалгуурт нийцсэн хөндлөнгийн аудитын компаниар шалгуулмаар байна. Шахмал түлшний үйлдвэрээс өөр санхүүгийн зөрчил байж магадгүй гэж хардаад байна. Энэ асуудлыг нэг тийш нь шийдэх санал гаргаж байна.

А.Ишдорж: За саналыг ойлголоо хувьцаа эзэмшигч учраас хөрөнгийн зарцуулалт, үр өгөөжийг нь хүртэх эрхтэй саналаа хэлж байгааг ойлгож байна. Биенийгээ хардаж сэрдэж байхаар аудит хийлгэх нь хэн хэндээ хэлэх үгтэй амар аудит хийлгэхэд татгалзах юм алга.

Д.Миеэгомбо: Аудит хийлгэнэ гэсэн тогтоол гаргах уу?

Д.Нэмэхбаяр: 29 саяар аудит хийлгэсэн биз дэ

Ю.Ариунтунгалаг: Интер аудит нь 29.700.0 төгрөгөөр гэрээ байгуулсан дүгнэлт тайлан нь ирсэн эх хувиараа байгаа.

Б.Онон: Хувьцаа эзэмшигчдийн хуралд аудит гэдэг асуудал ороогүй гэхдээ 8-р асуудал дээр бусад гэж оруулсан учраас компанийн сүүлийн 4 жилд аудит хийлгэхээр оруулна гээд төндэрээр санал хурааа.

Бүгд 100% дэмжив.

Ю.Батсайхан: За одоо хэлэлцэх асуудлынхаа дагуу явъя. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж танилцлаа миний хувьд нэмэлт асуулт алга.

Бүгд 100% дэмжив.

Б.Онон: Дараагийн асуудалд орьё. Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал Н.Данзан танилцуулна.

Ю.Батсайхан: Уулын үндсэн техниктэй холбоотой асуулт 2 автосонсмол авна гэж байна тэр бульдозерын хувьд ойлгож байна үнэхээр одоо музейд тавьчхаар олон жил болсон авах хэрэгтэй гэхдээ бүтээлийн тооцоо байгаа юу

Л.Энх-Отгон: ТЭЗҮ дээр 2 автосонсмол худалдаж авна гэж батлагдсан түүний дагуу хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд оруулсан.

Ю.Батсайхан: 2 автосонсмол бүтээлийн хувьд юу байгаа юм өмнө 800.000 мкв хөрс хуулсан ирэх оны хөрс хуулалт адилхан байхад яагаад ахиад 2 машин авах гээд байна. Сүүлийн 4 жил шинэчлэл хийсэн жил бүр өөр өөр машин аваад байх нь хэр зохимжтой юм бэ үүнийгээ 5 жилээр төлөвлөөд нэг төрлийн техник байвал зохимжтой сэлбэг хэрэгсэлээн бодоод.

Л.Энх-Отгон: Манайх техникийн шаардлагаа өмчийн газарлуу хүргүүлнэ. Худалдан авахаар тендэр зарлуулангуут техникийн тодорхойлолтыг нь манайх эндээс гаргаж явуулна тийм машинтай дүйцэхүйц гээд тэгээд шаардлагыг нь хангаад ороод ирэхээр марк нь өөрчлөгдчихдөг.

Ю.Батсайхан: Бүтээлээр хийсэн тооцоо байна уу ?

Л.Энх-Отгон: бүтээлээр хийсэн тооцоо байхгүй.

Ю.Батсайхан: Байхгүй бол хасая төлөвлөгөөтэй тооцоотой, үндэслэлтэй юм оруул. Би хувьдаа татгалзаж байна.

Н.Данзан: Жил ирэх тусам уулын ажлын нөхцөл байдал хүндэрнэ хөрс хуулалт, борлуулалт ихсэж байгаа зайлшгүй тийм ирээдүй байгаа ТЭЗҮ дээр ч байгаа жилд нэг таван төгрөг байвал техник хэрэгсэл дээр шинэчлэл хийж байвал ирээдүйд уурхайн бүтээл гарах нүүрсний хэмжээ ихсэх юм болов уу гэж бодсон жил болгон нийгмийн хариуцлага гээд баахан мөнгө тавьдаг бололцоо болбол техник технологийг шинэчлэж байя гэж бодсон юм.

Ю.Батсайхан: Би өөр саналтай байна. Нүүрсний чанарын судалгаа энэ судалгааг хиймээр байна ядаж энэ дүнгээр тавиад үүнийхээ зориулалтыг нь өөрчлө. Цахилгаан станцын ТЭЗҮ хийгдэж байгаа эд нар чанарын шаардлага гэж ярьж байгаа тэгэхэд гүний судалгаа байхгүй гадаргуугын судалгаа байгаа. Гүнрүүгээ нүүрсний чанар өөрчлөгдвөл цахилгаан станцын горим өөрчлөгдөнө. Тэгэхлээр ТЭЗҮ нь бас л адилхан үр ашиггүй болчно. Тэхээр энэ судалгаан дээр мөнгийг нь тавьмаар байна. Тэгээд цайны газар гээд 300 сая төгрөг тавьсан байна шинэ цайны газар барих гээд байгаа юм уу эсвэл тохижуулах гээд байгаа юм уу?

Н.Данзан: Шинээр цайны газар баръя гэж байгаа

Ю.Батсайхан: Хуучин цайны газраа яах уу

Н.Данзан: Барилга нь нилээн хуучирсан муу чулуун байшин бас багтаамж муу

Д.Миеэгомбо: Гаргах зардлуудынхаа дарааллыг зөв эрэмбэлж оруулж өгөх. Хайгуулаа хийж нөөцөө шинэчлэн тогтоох. Өмнөх хийсэн 1960 оны хайгуулаас арай өөр дүр зураг гаргаж болно. Тэгэхээр уурхайн талаар бидний төсөөлөл өөрчлөгдөнө. Төсөөлөл өөрчлөгдөхөөр шинээр төлөвлөгөө зохионо. Тэгээд тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтыг иж бүрэн хийх гэсэн зорилтууд өөрчлөгдөж магадгүй учраас энэ талынхаа юмыг илүү тавьж өгвөл яасын бэ? Гэсэн санал байна.

Ю.Батсайхан: Энэ 2 ажлаас тэрбум төгрөг гарч ирнэ үүгээр гүний хайгуул хийж нүүрсний чанарын судалгаа хийлгэх саналтай байгаа. Энэ 2 чинь дүндээ нэг л ажил нэг цооног гаргаал авна. Тэгэхээр энэ ажлаа эхлүүлээд авчихвал хамаагүй алсыг харсан ажил болно. Гэхдээ 25 сая тн нүүрс байгаа гэж анх хайгуул хийхдээ судалсан магадгүй 50-70 сая тн нүүрс болж өсөх ч юм билүү тэгвэл бид гадаадын хөрөнгө оруулалт татаж авч ажиллуулах энэ бол эргээд уурхайн хөгжих зам болно. Энэ ажлыг одоо хийхгүй бол дараа нь хийх цаг байхгүй.

А.Ишдорж: Төлөвлөгөөтэй танилцахад 300 саяар цайны газар барьхыг үр дүнтэй гэж бодохгүй байна. 2 автосонсмолын хувьд ч гэсэн үр дүн багатай гэж харж байна. Одоо бол уурхайн нөхцөл байдал хүндрээд байна гэж ойлгож байна нэг талруугаа хаваад тэгээд хөрс хуулалт нь зузаараад тэр хэмжээгээр хөрс хуулалтын зардал өсөөд байгаа саяын Батсайхны хэлдэгээр хайгуулын гэрээ хийгээд бүр тодорхой болгоод авбал яасын бид дахиад уурхайн карьерийг зөв эхлүүлэе одоо уурхайн карьерийг буруу нээснээс болоод асуудал үүсээд байна гэж яригдаад байх шиг байна. Нөөцөө тогтоогоод авчихвал дулааны цахилгаан станц баригдах гэж байна тэрэнд ч гэсэн хэрэгтэй тэгээд хайгуул хийлгэх нь зөв гэж бодож байна.

Ю.Батсайхан: Нүүрсний хайгуул, судалгааны ажил гэж оруулах саналтай байна. Тэгээд 2 автосонсмолын 600 сая төгрөг, цайны газрын 300 сая төгрөгийг хасаад хайгуулын болон чанарын судалгааны ажилд оруулж өгье.

Д.Нэмэхбаяр: Хайгуулдаа өгөх нь зөв

А.Ишдорж: Энэ саналыг дэмжиж байна.

Д.Нэмэхбаяр: Шахмал түлшний цалингийн зардал яасан.

Н.Данзан: Шахмал түлшний цалингийн зардал, хоол, ХАБ-ын зардлыг нягтлан тооцож оруулсан байна. Нийт 189.150.0 төгрөг 15 хүнээр тооцсон.

Миеэгомбо: Шахмал түлшний үйлдвэрийн ажилчдын цалинг бүтэн жилээр нь тооцоод тэгээд гүйцэтгэлээрээ гарах байх тэр болтол шийдвэр нь гарах байлгүй.

Ю.Батсайхан: 1 тэрбум төгрөгийн нийгмийн хариуцлага гэсэн үүнийг ногдол ашгаар тараалгах саналтай байна.

Д.Нэмэхбаяр: 1 тэрбум төгрөгийг ТУЗ дээр зөндөөн ярьсан олон тэгш ой тохиогоод ийм асуудал тавьж байгаа хууль зөрчсөн юм бол байхгүй.

А.Ишдорж: Аймгийн ой болно 2021 оны улсын төсөв батлахдаа аймгуудын төсвийг нилээн хасч баталсан тэхээр нилээн хүндрэлтэй байна. Энэ жил бол нилээн хямралтай бас ковидтой жил хүмүүстэй уулзаад ой болох гээд байна хандив тусламж өгөөч гэхээр боломжгүй байна. хийж төлөвлөсөн ажлууд маш их байгаа бид нар ярьж байгаад энэ жил уурхайгаасаа нэг удаа ийм хэмжээний дэмжлэг авъя гэж энэ асуудлыг тавьсан юм аа

Миеэгомбо: Авах нь бол аваад төлөвлөсөн юмандаа зарна биз харин авах хэлбэрээ нийгмийн хариуцлага гэх үү эсвэл ногдол ашиг хувиарлах юм уу гэдэг л байна.

А.Ишдорж: Би бол нийгмийн хариуцлага гэдгээр авна гэсэн саналтай байна.

Ю.Батсайхан: Өндөр дүнтэй хэлцэл учраас санал аваад явъя манай байр суурь бол нийгмийн хариуцлагын 1 тэрбумыг зөвшөөрөхгүй.

Б.Онон: Энэ бол их хэмжээний хэлцэлд орохгүй юм байна. Тийм болохоор ТУЗ-с баталж болно.

5-р асуудал. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2021 оны цалин урамшуулал болон зардал. ТУЗ-ийн зардлыг Ю.Ариунтунгалаг танилцуулав.

7-р асуудал. Аудитын байгууллагын зөрчилгүй гэсэн тайлан дүгнэлтийг Н.Данзан уншиж танилцуулав.

6-р асуудал. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох Б.Онон танилцуулав. 6 ердийн гишүүн, 4 хараат бус гишүүний материал ирсэн байна энэ 10 хүн дээр саналаа өгнө.

“Баянтээг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Ч.Гүнсэнхорол, Б.Ичинноров, М.Нинжбадгар, О.Батсүрэн, Ю.Батсайхан, Д.Миеэгомбо нар сонгогдсон байна.

“Баянтээг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр З.Дашзэвэг, Ц.Оюун, Н.Болдбаатар нар тус тус сонгогдсоныг баталсугай.

Д.Нэмэхбаяр: Хурлаар хэлэлцэх асуудлуудаа хэлэлцэж дууслаа. Тооллогын комиссийн шийдвэрийг Л.Ган-Отгон танилцуулна уу.

Л.Ган-Отгон: Тооллын комиссын тогтоол, шийдвэрийг танилцуулав.

Хурал 17 цаг 10 минутанд өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-ийн нарийн бичиг  /Б.Март/



 Д.НЭМЭХБАЯР